# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 10 өдөр Дугаар 58 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 6 нэрийн, нийт 8,099,150.00 (найман сая ерэн есөн мянга нэг зуун тавин) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 5,087,430.00 (таван сая наян долоон мянга дөрвөн зуун гучин) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Хосбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

13220423Ч

4-1 huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
32 дугаар тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, төрөл | Ашиглалтанд орсон он | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг) | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цаашид ашиглах жил | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт үнэ (төгрөг) |
| 1 | Зурагт /32 инч/ | 2016.05.16 | 3 | 375,550.00 | 1,126,650.00 | 2 | 3 | 304,966.66 | 914,900.00 |
| 2 | Зурагт /32 инч/ | 2016.07.08 | 1 | 375,500.0 | 375,500.00 | 2 | 1 | 304,966.7 | 304,966.67 |
| 3 | Төгөлдөр хуур /ямаха/ | 2011.12.26 | 1 | 4,000,000.0 | 4,000,000.00 | 2 | 1 | 2,075,000.0 | 2,075,000.00 |
| 4 | Телевизор /lcd самсунг 40 инч/ | 2011.12.26 | 1 | 1,089,000.0 | 1,089,000.00 | 2 | 1 | 508,315.0 | 508,315.00 |
| 5 | Телевизор /lcd самсунг 40 инч/ | 2011.12.26 | 1 | 1,199,000.0 | 1,199,000.00 | 2 | 1 | 699,981.7 | 699,981.67 |
| 6 | Цаас устгагч /deli 9930/ | 2016.07.06 | 1 | 309,000.0 | 309,000.00 | 2 | 2 | 292,133.3 | 584,266.66 |
| | Нийт дүн | | | | 8,099,150.00 | | | | 5,087,430.00 |